



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

20¹⁶ оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Төрийн ордны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Засгийн газрын 2016 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 50 дугаар тушаалын 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“д/Чанарын менежментийн хэлтэс.”

2. Мөн тушаалын 4 дэх хэсгийн “захирал 1, дэд захирал 1,” гэснийг “дарга 1, дэд дарга 2,” гэж өөрчилсүгэй.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 50 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.1 дэх заалтын “захирлыг” гэснийг “даргыг”, 4.2 дахь заалтын “захирал” гэснийг “дарга”, 4.3 дахь заалтын “дэд захиралтай” гэснийг “дэд даргатай”, “захирал” гэснийг “дарга”, 4.4 дэх заалтын “Захирлын” гэснийг “Даргын”, “дэд захирал” гэснийг “дэд дарга”, 4.5 дахь заалтын “захирал” гэснийг “дарга”, 4.6 дахь заалтын “Захирал” гэснийг “Дарга”, 4.6.4. дэх заалтын “захирлын” гэснийг “даргын”, 5 дугаар бүлгийн 5.1 дэх заалтын “Газрын бүтцэд дор дурьдсан нэгж ажиллана.” гэснийг “Газрын зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар батална.” гэж тус тус өөрчилсүгэй.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ